



Хууль эрх зүй

МОНГОЛ ДАХЬ ӨНӨӨГИЙН ГЭМТ ЯВДЛЫН ШАЛТГААН

"Нийгэм болгон өөрийн дүр төрх, соёл, ёс суртахууны шашин,
эдийн засгийн нөхцөлдөө тохирсон гэмт хэрэгтэй байдаг"

Г.Манхейм

Хилийн албаны бие бүрэлдэхүүн болон Хилийн Цэргийн Сургуулийн сонсогчдын хууль эрх, албан хэргийн мэдлэгт зориулж өнөөдөр бараг л бүгд ярьж эмзэглэж байгаа боловч эрх зүй, криминологи байр сууринаас цогцоор ойлгож бодит баримтаа олохгүй байгаа ёсон асуудлын нэгэн болох өнөөгийн гэмт явдлын шалтгаанаар зохих хэмжээний зүйлийг ойлгуулах гэж зорьсонд энэ бяцхан өгүүллийн учир оршино.

Криминологийн шинжлэх ухаан гэмт явдлын шалтгааныг дараахь хүрээнд авч үздэг. Үүнд:

1. Эдийн засгийн харилцаанаас үүдэлтэй шалтгаан
2. Нийгмийн харилцаанаас үүдэлтэй
3. Улс төрийн сонирхлын үүдэлтэй шалтгаан
4. Нийгмийн зан суртахуунаас үүдэлтэй шалтгаан
5. Гэмт хэрэг үйлдэгдэхэд тусалж буй нөхцөлүүдээс үүдэлтэй гэнэ.

1950-иад оны үеэс БНМАУ-д гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл гэсэн ойлголтыг бараг л үгүйсгэж байсан боловч эрх биш нийгмийн хөгжил цагийн ая дагаж 1970-аад оны үед орж байж судалж эхлэх бодитой чигт орж байсан юм. Өнөөдөр Монгол Улсад гарах гэмт явдлын шалтгаанд ихэд өөрчлөлт оржээ. Юуны өмнө социалист нийгэмд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөл байхгүй байгаа энэхэн хэсэг илрэл нь хөрөнгөтөн нийгмийн хор уршиг гэж үзэж байснаас шийдвэртэй саллаа.

Одоо онолын судалгааны зэрэгцээ гэмт явдлын шалтгааныг судлахад илрэл, үйл явц, гэмт хэрэг энэхүү хангалттай бүрдсэн нь ядуурал, ажилгүйдэл, хараа хяналтгүй хүүхдүүд, янхандалт, архидалт; хүссэн санаснаа хийж болох дур зоргийн балмад ойлголт зэрэг олон зүйлээр тодорхойлогдож болохоор байна.

Тэгвэл бид гэмт явдлын шалтгаан нөхцөлийг хуучин нийгмийн

үлдэгдэл, түүний хор уршиг, эсвэл хүмүүсийн сэтгэл зүйн дутагдал гэх мэтээр тайлбарлаж болохгүй бөгөөд шалтгаан нь нийгмийн харилцаан дахь нөхцөл байдлын цогц мөнөөр ойлгох л хэрэгтэй болно. Сүүлийн үед гэмт явдлын шалтгааныг нийгмийн амьдралын харилцаан дахь бүх салбар, төрөлтэй холбож байгаа юм. Үүнд эдийн засаг, хуваарилалтын харилцаатай бүр ч холбоотой тул манай улсын одоогийн байдал, нийгэм эдийн засгийн хямрал нь гэмт явдлын шалтгаан мөнөөс мөн. "Гал унтраах", цоорхойг нөхөх, хийсэн болж харагдах элдэв цаг зуурын илрэлүүд тодорхой үр дүнд хүрээгүйн гадна Монгол Улсын түүх амьдралын онцлогийг харгалзахгүйгээр хатуу харгис барууны капитализмаар түрээ барьж чадваргүй бодлого, дадлагагүй арга тулгаж тэдгээрийн ард амжуулах зальт санаархалаа хаацайлах болсон нь байдлыг улам хүндрүүлсэн юм.

Энэ нь гэмт явдлын гаралтад шууд нөлөөлсөн, тэтгэсэн, хөөрөгдсөн, шинэ шинэ арга баширт сургасан. Гадаадын хөрөнгө оруулалт, зээл туслалцаа өмч хувьчлал, үйлдвэр заводын хаалга барилт нь бүгд үл ойлгогдож чухам хэний гар, хэний арга ажиллагаа, хаана эхэлж, хаана явж, хаана дуусч байгаа нь мэдэгдэхээ болив.

Хувьчлалыг "эрүүл" бусаар компаничлан явуулж, эдийн засгийг удирдахад төрийн оролцоо баримжаагаа алдаж, худалдаа арилжаа чөлөөтэй болж, социализмын үед бүгд л хувийн хөрөнгөгүй байсан гэх боловч хэсэг бүлэг хүмүүс юу эсийг наймаалалцан бэлтэй болцгоож түшмэд албан тушаалтнууд гэмт бүлэглэлүүдэд хэт илэрхийгээр "Сэм" ашиглагдаж зохион байгуулалттай гэмт хэргийн хүчирхэг үндэс бүрэлдэн тогтлоо. Ингээд зохион байгуулалт, харилцаа, өөр хоорондын туслалцаа дээрх нууцхан гэмт бүлэглэлүүд эдийн засгийн хүндрэл, нийгмийн шилжилт, бэрхшээлээс тэдний баяжих, хөрөнгөжих боломжтой болж коррупци-авилгалын эх суурь бий болов. Эдийн засгийг улам чөлөөтэй болгон төрийн болон олон нийтийн өмчийг хямд үнээр хувьд шилжүүлсэн болон ийнхүү шилжүүлэхийн өмнө чадал хүслийнхээ хэрээр зөөцгөөсөн нь эдийн засагт эрүүгийн элементүүд шургалан орох нөхцөл боломжийг хангасан юм. Энэ байдлаас л гэмт бүлэглэлүүд эдийн засаг, санхүү зээл, банк, хөрөнгийн зах зээл болон гадаадын хөрөнгө оруулалт, эдийн засгийн гадаад харилцаа зэрэг салбарт саадгүй нэвтрэн орцгоосон. Социологийн судалгаанд хамрагдагсдын 60-аад хувь нь зөвхөн хэсэг бүлэг хүмүүс улс орны өмч хөрөнгийг завшин, хууль бусаар, хулгайн замаар баяжсан гэж үзсэн байна. Мөн санал асуулгад оролцогчдын 40 гаруй хувь албан тушаалыг ашиглах, хээл хахууль авах, хуурч мэхлэх нь баяжих гол арга мөн гэдгийг зөвшөөрсөн байдаг. Бүр Засгийн

Газар ссрөө улсын өмч хөрөнгийг гадаадад нууцаар гаргах ажлыг эхэлж гардан хэрэгжүүлсэн нь үндэсний эрх ашигт ноцтой хохирол учруулсан төдийгүй муу зүгийн "томоохон хичээл сургалт" болсон юм.

Дээрхээс гадна эдийн засгийн хямралын гол илрэл болох үйлдвэрлэлийн уналт, цалин тэтгэврийг хугацаанд нь тавьж чадахгүй явдал, ил болон нууц ажилгүйдэл нь гэмт хэрэг гарах нөхцөл боломжийг бүрдүүлэгч гол хүчин зүйлүүд юм. Үүний дээр зах зээл эдийн засгийн явц, гэмт явдлын шинэ хэлбэрүүд, компьютерийн гэмт явдал, санхүү банкны зальт явуулга, "мөнгө угаалт" зэргийг төрүүлэх явдал ч манайд хоцорсонгүй.

Манай улс ерээд онд зах зээлийн эдийн засагт шилжихэд бэлэн бус байв. Ийм зайлшгүй нөмөрч ирэх логик хандлагыг ч социализмын төр засаг, ард олноос нууж байсанд оршдогоос гадна их эртний төр ёсны уламжлалтай энэ орон заавал чиглүүлэг зааварчлага хүлээдэг байсан нь нэг талаар цагаан сэтгэлийн, нөгөө талаар бэлэн хангалт хийдэг мал аж ахуйдаа дулдуйдсаных байснаас улс төр, эдийн засгийн гүн хямрал, замбараагүй байдал, гэмт явдал өсөх "хүчтэй давалгааг" даагаагүй юм.

Эдийн засаг, зохион байгуулалт, санхүүгийн боломжоос хилийг зохих хэмжээнд хамгаалж чадахгүйд хүрэх аюул мэдрэгдэж байгаагийн дээр эд зүйлс хууль бусаар нэвтрүүлэх, машин, хориглосон, муудсан их хэмжээтэй хүнсний бүтээгдэхүүн орж ирэх болсны дараа хүний наймаа, хар тамхи зэрэг улс хоорондын чанартай гэмт явдал хүчээ авч байна.

Сүүлийн 10 жилд нийгмийн хамгаалалын асуудал орхигдсон буюу ор нэр төдий байгаа нь гэмт явдалд нөлөөлсөн бөгөөд судалгаанаас үзэхэд иргэдийн 70 орчим хувь дундаас доогуур амьдралын түвшинд байдаг нь цөөн хэсэг баяжин, бусад нь ядууралд орж улмаар хүмүүс өмч хөрөнгөөр ялгаварлагдаж, нийгэмд таагүй байдал буй болгоход хүргэдэг талтайг баталж өгөв. Нийгмийн таагүй тогтворгүй байдалд өмч хөрөнгөтнүүдийн хоорондох тэмцэл, албан тушаалтнуудын хууль бус ажиллагаа, хүнд суртал, дураар авирлалт, нөгөө талаас ажилгүйдэл ядуурал, нутаг сэлгэж шилжигсэд, ёс суртахуунаар унагсад, алдаа гажуудлаас ашиг хайгсад, илэрхий тус болж Сэйна. Эд бүгд хяналт зохицуулалтаас гарсан нь хууль сахиж биелүүлдэг иргэдийн тоог цөөрүүлж эхэлсэн юм. Үнэ төлбөргүй суралцах, эмчлүүлэх боломж алдагдаж дийлэнх гэр бүлд хүүхдээ хүмүүжүүлэх, чөлөөт цагийг тэдний хамт тухтай өнгөрүүлэх асуудал хүндрэлтэй болж ирснээс хараа хяналтгүй тэнэмэл хүүхэд, сургууль

завсардагсад, хүүхэд насны оногдсон хувь заяанд сэтгэл дундуур байгсдыг гэнэтээр буй болгов. Эндээс гэмт явдалд холбогдогсод улам олноор буй болж улс орны маргаашид тэд хэн байх тодорхойгүй болж байна. Улс орны иргэдийг түүний дотор эрчүүдийг онцгой сайнаар сургадаг цэргийн алба ёс төдий болсон нь хамаагүй зүйл бишээ.

Архидалттай тэмцэх төрийн нэгдсэн бодлогогүйгээс архидан согтуурах, согтуугаар гэмт явдалд холбогдох нь ихсэж ирсэн нь нийгмийн эрүүл харилцааг олон талаар булингартуулж байгаа юм. Төрийн хяналтын хуучин хэлбэр аргыг бүрэн халснаар нийгэм бүхэлдээ хяналтгүй болж түүнийг орлож чадах шинэ механизм төдийлөн чигээ олох хандлагаар муу байгаа нь гэмт явдлын өсөлтийг онцгой ахиулсан болно.

Төр, гэмт явдалтай тэмцэх улс төрийн бодлогоо барьж чадахгүйд хүрч хаа хаанаа ардчиллыг анархизмаас ялгахаа больсноос ардчиллын үе дэх хууль, хүчний байгууллагын асуудал эргэлзээнд орсон нь хүний эрх, эрх чөлөөгөөр бамбай болгож хүссэнээ хийх, дураар авирлах явдлыг улам үржүүлж байна. Төрийн удирдах үүрэг алдагдаж эхэлснээр засаглалыг хуваасан байгууллагуудын өөр хоорондоо эвгүй байх шалтаг боломжийг ихэсгэж нийгэмд засаглалыг ард түмэн ч бус, Ер нхийлөгч бус, хууль тогтоох байгууллага ч бус, Засгийн Газар ч биш харин эрүүгийн элемент, мафи, зохион байгуулалттай гэмт хэргийнхэн хэрэгжүүлэхэд улам ойртож ирсэн нь бүр онцгой нөлөө шалтгаан болов. Энэ чиглэлээр судалгаа явуулбал оролцогчдын талаас дээш хувь санал нэгтэй байх нь дамжиггүй.

Завсарын үеийн эхлэлийн шатанд эрх зүйн хамгаалалт аль ч салбарт алдагдсанаас хууль бус үйлдлийг, хээл хахууль авахыг, зай хийдэл байвал "амжуулж" болохыг илэн далангүй ухуулах хандлага ч дэлгэрч байлаа.

Өнөөдөр хууль тогтоох байгууллага, төрийн гүйцэтгэх засаглалын зарим хэсэг авилгалд автаж нэр хүнд унасаар байхын гадна ноцтой хэрэг, луйврын эх сурвалж байж болохыг ард олон үгүйсгэхгүй байна. Хуулиар хориглоогүй бүхэн хийж болох үндэстэй ч зан заншил, ёс суртахуунаар зохицуулагддаг зүйлүүдийг амьдралд ихээхэн байдгийг мартуулах, мартахыг хүсэгчид хүрээгээ тэлж байгаа явдал юм. Энэ мэтээр төрийн албадлага дутагдаад байгаа нь цаашид овог ястны "хийрхэх", салах, эв түнжин алдрах өвчнийг ч сэргээхгүй гэх газаргүй. Хэний ч амаар ярьж байгаа нь үл мэдэгдэх, "ярьж харагдах" гэсэн юмуу, алсын ашгийн төлөөх зарим түшээдийн газар

хувьчлалын асуудалд төрийн зохицуулалт дутагдаж байгаа буюу үл ойлгогдоод байгаагаас газар хувьчлалт хүний аминд хүрэх эхний дохиогоо өгөөд удаж байна.

Нийгмийн оюун санаа- ёс суртахууны хүрээнд сөрөг талгүй үзэгдлүүд ихээхэн хуримтлагдсан нь нийгмийн хэв журам тогтоох гэмт явдалтай тэмцэхэд мэдэгдэхүйц нөлөөлөөд байна. Ёс суртахуун болон тухайн хүний зөв мэдрэмж гэмт явдлаас зайлсхийх, тэмцэх, урьдчилан сэргийлэх, саармагжуулахад нэн ач холбогдолтой нь эргэлзээгүй бөгөөд түүний эсрэг гагцхүү ёс суртахууны байр сууриар сөрөн зогсдог юм. Энэнд хууль хамгаалах байгуулагынх ч адил. Үндэстнийхээ ёс суртахууны үнэ цэнэтэй зүйлсийг ихэнхийг үгүйсгэсэн боловч ёс суртахууны зохицуулалтын шинэ тогтолцоог бүрдүүлэх боломжийг баримжааг бий болгоогүйгээс одоо бидний гэх ёс суртахууны нийтлэг өнгө бүүдгэр байгаа нь гэмт явдлын үржих хөрсийг улам өргөсгөж өгдөг явдал болно.

Өнөөдөр шүүн таслах ажиллагаа хүмүүжлийн ач холбогдлоо олон талаар алдаж урьд нь хэдхэн жилийн өмнө эрүүгийн хэрэгт холбогдох, архидалт, увайгүй авирлаж ялаас мултран гарах оролдлогыг шившиг гэж үздэг байсан бол одоо энэ ойлголт хачин өөрчлөгдөж ерийн л нэг улаан гэрлээр зам хөндлөн гарах төдий мэт болсон. Дээрх бүгд төрд итгэх, улмаар бишрэн хүндлэх бодлыг алдагдуулж иргэд түгшингүй, ирээдүйд итгэл муутай байх, өнөөдрийн тарчиг байдлаасаа илүү үр хүүхэд хойч үеийнхэндээ зовних явдлыг ихэсгэж байгаа нь амьдралын бүхий л эд эсэд нөлөөлж байна. Эдгээр нийгмийн оюун санаа, ёс суртахууны салбарт гарч буй сөрөг үзэгдлүүд Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэл мэдээллийн чөлөөт эрхийг дагалдан хүчирхийлэл, шалиглал, аллага, луйварыг сурталчлах боломжийг хангаж байгаа юм. Энэ чиглэлээр зохицуулалт хоцрогдсон байлаа ч хэн анхаарч биелүүлж байгаагийн шалгуур, тооцоо нь хэнд ч хэрэггүй мэт. Ер нь хууль хамгаалах байгууллагын ажиллагааны "амь зогоосон байдал" боловсруулагдаж буй хуулиудын хийдэл, цоорхой, урьдчилан сэргийлэх ажиллагааны орхигдол, эх газрын эрх зүйн тогтолцоог далайн орнуудын эрх зүйн тогтолцоотой холион бантан болгосон өөрчлөлтүүд гэмт явдлын шалтгааныг өөрөө хэлбэршүүлээд байгаад оршино. Германы нэрт криминологич Хайморкомп "Хууль хамгаалах байгууллагууд гэмт явдлыг оршин тогтнож өөрсдөө амьдарч байгаа" илрэл байдгийг судалгаандаа дурдсан байдаг нь үнэнд маш ойр сонсогддог юм. Төр хууль хамгаалах тогтолцоог төдийлөн гартаа зөв атгаж чадахгүй байгаа явдал ч харагдаж байна.

Энэ байдал нь гэмт явдалд аятай нөхцөл болох нь дамжиггүй. Хууль хамгаалах байгууллагууд хэн нэг түр цагийн мэдэлтний гар дор хуваагдаж өөрчлөгдөж байдаг, мэргэжсэн ажилтнууд нь тогтонги үр бүтээлтэй ажиллах баталгаагүй өөр хоорондоо харилцан уялдаа муу, тэр ч байтугай бүр "хөлөө гэдсэндээ хийлцсэн" зэрэг нь гэмт явдал, гэмт элемент, гэмт бүлэглэлийн "бахтай" идэш болж байдаг нь онцгой анхаарах шалтгаан юм.

Мөн гэмт явдалтай тэмцэхэд олон нийтийн нөлөө, идэвхи, үүрэг, алба алга болсон зэргийн нийлмэл цогц шалтгаанууд оршиж байна.

Өнөөгийн шатанд гэмт явдлыг таслах, багасгах, саармагжуулах, урьдчилан сэргийлэх бүхий л ажиллагаанд их хүч, мэрийлт, зөв зохион байгуулалт, хэтийн болон ойрын төлөвлөлтийг үндэслэлтэй хийх хэрэгтэй байгаагийн дээр иргэн бүрийн санаачлага чармайлт онц чухал. Их эзэн Чингис хаан "Сэтгэлээ цэвэршүүлж чадсан тэр цагт эх нутгаа хулгайгаас цэвэрлэж чадна" гэсэн нь энэ их нөр ажилд бидний чиг чигээ олох гэрэлт бамбар зайлшгүй мөн.



Багш. Л.Сандагсүрэн